

**“ТАЛЫН ГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2025 оны 4 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 1

Рашаант

Компанийн 2024 оны үйл ажиллагааны тухай

“Талын гал” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлт, тавьсан илтгэлийг хэлэлцээд тэмдэглэх нь:

Тус компанийн гүйцэтгэх удирдлага, Төлөөлөн Удирдах Зөвлөл 2024 онд үйлдвэрлэлийн төлөвлөгөөт үзүүлэлтийг биелүүлэх, жигд ажиллагааг хангах, ажлын зохион байгуулалтыг дээшлүүлэх талаар зохих арга хэмжээ авч хэрэглэгчдийг нүүрсээр хангах үндсэн үүргээ амжилттай биелүүлсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

Нэг. “Талын гал” ХК-ийн 2024 оны үйл ажиллагаанд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг зөвшөөрч, тайлангийн хугацаанд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс хэрэгжүүлсэн ажлын дүнг хангалттай гэж үзсүгэй.

Хоёр. Доорхи зорилтыг 2025 онд дэвшүүлэн ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшинг нэр төрлөөр нь чанарын өндөр үзүүлэлтээр ханган биелүүлэх.
2. Тоног төхөөрөмж, машин техникийн засварын ажлын чанарыг сайжруулах, гэнэтийн эвдрэл саатал, сул зогсолтыг эрс багасгах, зардал хямдруулах, нүүрс экспортод гаргах талаар тавьсан зорилтыг ханган биелүүлэх дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

3. Хяналт шалгалт, хараат бус дотоод аудитын ажлын үр нөлөөг дээшлүүлж, компанийн санхүүгийн чадварыг сайжруулахад бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллах.

Гурав. Хувь нийлүүлэгчдийн хурлаас гарсан санал шүүмжлэлийн мөрөөр цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, компанийг илүү үр ашигтай ажиллуулахыг Гүйцэтгэх захирал /С.Цэрэндондов/-д үүрэг болгосугай.

Дөрөв. Тогтоолын биелэлтийг хангуулах талаар гүйцэтгэх удирдлагад дэмжлэг туслалцаа үзүүлж түүний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл /У.Батсуурь/-д даалгасугай.



ХУРЛЫН ДАРГА:

У.БАТСУУРЬ

НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА:

С.ЦЭРЭНДОНДОВ